

КАТАРЫН ХОЙГ ДАХЬ КАТАР УЛС

*Л.Бэгзжав**

Ази тивийн баруун өмнөд хэсэгт, Персийн булангийн Катарын хойгт орших, хойгийнхоо нэрээр нэрлэгдсэн 11437 км² багахан газар нутагтай, дэлхийн баян орны нэг нь Катар улс юм. МЭӨ 3000 орчим жилийн өмнө эртний Финикчүүд амьдран сууж байсан Катарын хойгийг эртний Грекийн газар зүйчид, Ромын түүхчид, Арабын эрдэмтэд “Катала”, “Каталар”, “Каталия” гэж түүх сурвалжид тэмдэглэж байсан нь хувирсаар өнөө “Катар” гэгдэх болжээ.¹

Одоо 885 мянган хүн амтай, нэг км² газар нутагт дунджаар 60 хүн ногддог, Катар улсын хүн амын 40% нь катарчууд буюу араб, тус бүр 18% нь пакистан, энэтхэгчүүд 10% нь иранчууд ба бусад нь Зүүн Өмнөд Азийн орнуудын цагаачлагчид ажээ. Албан ёсны хэл нь араб хэл ч, англи хэлийг өргөн хэрэглэдэг.

Түүхэндээ удаа дараалан эртний Араб, Ираны хаант улсын нэг хэсэг байсан Катар МЭ VII зуунаас ислам шашин дэлгэрсэнээр өнөө хүн амын 95% нь мусульманы суннит урсгалын ваххаби шашныг шүтдэг. 1517 оноос Португаль, Османы эзэнт улс, Перс буюу Ираны ноёрхолд, 1882 оноос Английн асрамжийн орон болон түүхийн их нугааг туулсан Катар улс 1971 оны 9-р сарын 1-нд тусгаар тогтносон, бүрэн эрхт улс болсноо дэлхий дахинаа зарласан байна. Үндэсний баяраа жил бүрийн 9-р сарын 1-нд тэмдэглэдэг, тусгаар тогтноод 36 жил болж буй Катар нь /The State of Qatar/ хаант засаглалтай улс бөгөөд тус улсад улс төрийн нам, байгууллагын үйл ажиллагааг хориглодог.

Хуурай зам, далайн агаарын цэргийн хүчинтэй, 11800 сайн дурын цэргийн албан хаагчидтай, АНУ, Англи, Францын орчин үеийн зэвсэглэлээр хангагдсан, эдгээр гурван оронтой цэргийн хамтын ажиллагааны гэрээтэй.

Эртнээс Катар улс Персийн булангийн их хөлийн зах зээл, сувд олборлодог бүс нутаг болсоор ирсэн ба Доха, Умм-Саид зэрэг томоохон боомтод өдөр бүр хэдэн зуун хөлөг онгоц, хэдэн мянган далайчид бөөгнөрч байдаг.

Персийн булангийн бусад орны нэг адил Катар нь газрын тос үйлдвэрлэгч, экспортлогч орон, нефтийн нөөц нь 504 сая тонн, жилдээ 6-7 тэрбум ам.долларын орлого буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 60%-ийг нефтийн үйлдвэрлэлээс олдог.² Өнгөрсөн зууны 80-аад оноос хойш олон улсын зах зээл дээр нефтийн үнэ тогтвортой бус болсоны улмаас Катарын засгийн газар аж үйлдвэрийн бусад салбарыг

* Л.Бэгзжав - доктор (Ph.D), дэд профессор

хөгжүүлэхээр анхаарч орлогын өөр эх булгийг олон төрөл болгох бодлого явуулсан. Катарын байгалийн хийн нөөц нь 8490 тэрбум шоо метрээр хэмжигддэг нь дэлхийд 3 дугаарт орох ба жилдээ байгалийн хийнээс 3 тэрбум ам.долларын ашиг олдог. Энэ нь дотоодын нийт бүтээгдэхүүний 20%-ийг эзэлдэг байна. Экспортын гол бүтээгдэхүүнээ Япон, БНСУ, Сингапур зэрэг улсад гаргадаг.

Тус орны газар нутаг бараг бүхэлдээ чулуурхаг цөл газар, хөрс шороо нь үржил шим муутай, гадаргын усны нөөц хомс, жилд орох хур тундасны хэмжээ тун бага байдагаас хөдөө аж ахуй газар тариалангийн хөгжил тааруу, үр тариа, хүнсний ногоо, жимс, мах, өндөг, сүү зэрэг хүнсний гол бүтээгдэхүүнээ гаднаас импортоор авдаг, загас хясаа зэрэг далайн бүтээгдэхүүнээр үндсэндээ өөрийгөө хангадаг. Катарчууд үхэр хонины мах голлон иддэг, бүхэл хонины шарсан мах, таван цулын будаатай хуурга, малын мөч мах, шарсан загас, наргилын чавга, усан үзэмтэй хуурсан будаа идэж, хар цай, кофе уух дуртай ажээ. Исламын орнуудын нэгэн адил архи уух, гахайн мах идэхийг цээрлэдэг. Катарын засгийн газар тариачдал үрийн будаа, бордоо, хөдөө аж ахуйн машин техникийн үнэгүй олгох бодлого явуулж ард иргэдийнхээ мод тарих санаачлагыг хөхиүлэн дэмжиж, хагалсан газрыг өргөтгөхөд ихэд анхаарч байна. Хувийн хэвшлийг дэмжих болон нээлттэй засгийн газрын бодлого баримталдаг Катарын эдийн засгийн өсөлт жилд 8.8% /2005/ байдаг ба нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн нь 28300 ам.доллараас давдаг дэлхийн толгой баян орны нэг юм. Батлан хамгаалах жилийн төсөв нь ДНБ-ий 10% буюу нэг тэрбум ам.доллараас давдаг ч нийгмийн бодлого нь ард түмэндээ өгөөмөр хүртээмжтэй Катар улсад эмнэлэгийн бүх үйлчилгээ үнэ төлбөргүй, бүх шатны боловсролыг үнэ төлбөргүй олгодог төдийгүй сурагчдал ном сурах бичиг, соёлын бараа, өмсөх хувцасыг нь ч улсаас хангадаг, амжилттай сайн сурсан оюутныг гадаадад сургах тэтгэмж олгох зэргээр урамшуулдаг. Тус улсад 200 орчим дунд сургууль, араб болон гадаадынхны хувийн сургууль 48 байдаг ба 1977 онд анхны их сургууль байгуулагджээ. Катарын цорын ганц энэ их сургууль дотроо дээд сургуультай, 7000 орчим оюутан, 500 гаруй багштай аж. Хүн амын дундаж наслалт эмэгтэйчүүд 76, эрэгтэйчүүд 71 хүрдэг байна.

Засаг захиргааны хувьд 9 хоттой. Хотуудыг хооронд нь 900 км урт засмал замын сүлжээгээр холбосон бол нийслэл Дохагийн олон улсын нисэх онгоцны буудлаас Ази, Европын 17 шугам өдөр тутам нислэгтэй байдаг. Манайхаас 5 цагийн зөрүүтэй Катар нь өөрийн риал гэдэг мөнгөн тэмдэгттэй. Нийслэл Доха хот цэвэрхэн, амар тайван, өдрөөс өдөрт цэцэглэн хөгжиж, дэлхийн олон орны аялагч жуулчдын сонирхлыг татсаар буй байгаль, соёл иргэншлийн үзэмж хосолсон газар юм.

Эх газраар Арабын Нэгдсэн Эмирт Улстай хиллэдэг, Бахрейн, Саудын Арабтай далайгаар зааглагдсан оршдог Катар улс халуун бүсийн цөлийн уур амьсгалтай, хуурай аагим халуун, 4 дүгээр сараас 10 дугаар сарыг зуны улирал гэх, +46.С хүртэл халдаг, өвөл нь хуурай сэрүүн хамгийн хүйтэн нь +7.С байдаг. Далайн түвшинээс нам дор газар орших тул Арабын орнуудын дотор хамгийн халуун дулаан газар юм. Катарчууд халуун дотно зочломтгой зантай нь арабчуудын онцлог, тэдний уламжлалт ёс билээ. Морь, тэмээ унах дуртай, гадаадын зочдыг машид хүндэтгэдэг, зочдоо кофегоор далайх дуртай. Өвөрмөц зан үйлтэй, катарчууд арабын уламжлалт хувцасаа өмсөхөөс гадна залуучууд нь нэлээд нээлттэй. Эмэгтэйчүүд нь алтан ээмэг, бөгж зүүх дуртай, богино банзал өмсөхийг, тэр байтугай гадаадынхан өмсөхийг ч хориглодог. Эмэгтэй хүн танихгүй хүнтэй холбоо тогтоохыг цээрлэдэг заншилтай.³

Гадаад бодлогын хувьд төвийг сахисан, эвсэлд үл нэгдэх бодлого явуулж Исламын орнуудын эв нэгдэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх, сайн хөршийн найрсаг харилцаатай байхыг эрмэлздэг. Монгол Улс Катар улстай 1998 оны 1 дүгээр сарын 21-нд албан ёсны дипломат харилцаа тогтоож, элчин сайд нараа солилцсон бөгөөд хоёр орны хооронд “Эдийн засаг, худалдаа, техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр”, “Хөрөнгө оруулалт, давхар татварын хэлэлцээр”, “Мал эмнэлэг, хорио цээрийн хэлэлцээр”, “Ургамал хамгаалал, хорио цээрийн хэлэлцээр” байгуулахаар бэлтгэл ажилдаа ороод байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Жан Жунсян. Shijie gegou guoming jijin. Бээжин. 1987, 16-р тал
2. Ван Чэнжя. Улс орнуудын байдал (Ази). Geguo gaikuang. (yazhou). Бээжин. 2002. 117-р тал.
3. Yazhou zhi shi xituce. Бээжин. 2001. 102-103-р тал.